



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ТӨСВӨӨС ОЛГОСОН ХӨРӨНГИЙН 25.8 ХУВИЙГ ЗОРИУЛАЛТ БУС ЗҮЙЛД ҮР ДҮНГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

АУДИТЫН НЭР: БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТӨСВӨӨС ОЛГОСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН /2018-2019 он/

АУДИТЫН КОД: АРА-2020-/03/-ГА

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр

Утас: 7033-3141 Цахим хаяг: Ulambayard@audit.gov.mn

Цэцэрлэг хот
2020 он

Аудитын менежер Т.Байгалмаа

Утас: 7033-2860 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

ГАБ-ийн ахлагч, Ахлах аудитор Д.Нэргүйбаатар

Утас: 7033-3019 Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

ГАБ-ийн аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 7033-3019 Цахим хаяг: Tsoq-erdeneg@audit.gov.mn



<p><u>Тайлан бэлтгэсэн:</u></p>	<p>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</p>	<p>3</p>
<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газар</p>	<p>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ</p>	<p>4-6</p>
<p>Тэргүүлэх аудитор: Д. Уламбаяр</p>	<p>БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАХ ТӨСВИЙГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.</p>	<p>7</p>
<p>Аудитын менежер: Т.Байгалмаа</p>	<p>1.1. Аймгийн засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилаагүй, ИТХ-аас хэрэгжилт, үр дүнд хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй байна.</p>	<p>7-9</p>
<p>Ахлах аудитор: Д.Нэргүйбаатар</p>	<p>1.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах төсвийг батлахдаа хуульд заасан хувь хэмжээг мөрдөөгүй байна.</p>	<p>9-11</p>
<p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ</p>	<p>БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХУВААРИЛСАН ХӨРӨНГИЙН 25.8 ХУВИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН АРГА ХЭМЖЭЭНД ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.</p>	<p>12</p>
<p>2020 оны 12 дугаар сар</p>	<p>2.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг журамд заасны дагуу төлөвлөөгүйгээс 208.0 сая төгрөгийг үр дүнтэй зарцуулаагүй байна.</p>	<p>12-13</p>
<p>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</p>	<p>2.2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.</p>	<p>13-14</p>
<p>www.audit.mn</p>	<p>БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСНЫ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ҮР НӨЛӨӨ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.</p>	<p>15</p>
<p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70332860 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу</p>	<p>3.1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.</p>	<p>15-16</p>
<p>ХАЯГ: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 311 тоот</p>	<p>ДҮГНЭЛТ.....</p>	<p>17</p>
<p></p>	<p>ЗӨВЛӨМЖ.....</p>	<p>18-19</p>
<p></p>	<p>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ</p>	<p>20</p>
<p></p>	<p>ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ</p>	<p>21</p>
<p></p>	<p>ХАВСРАЛТУУД</p>	<p></p>



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АРА	Архангай аймаг
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
МУЗГ	Монгол Улсын засгийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 2018, 2019 оны төсвийн төлөвлөлтийн харьцуулсан байдал	9
Хүснэгт 2	Гэрээнд заасан төлөвлөсөн хугацаанаас хоцорч хүлээлгэн өгсөн ажлын жагсаалт 2019 он	13

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хэмжээгээр тооцсон зардлын хэмжээ ба баталсан төсвийн харьцуулалт	10
Дүрслэл 2	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хэмжээгээр тооцсон зардлын хэмжээ ба баталсан төсвийн харьцуулалт	11
Дүрслэл 3	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хэмжээгээр тооцсон зардлын хэмжээ ба баталсан төсвийн харьцуулалт	11
Дүрслэл 4	Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хэмжээгээр тооцсон зардлын хэмжээ ба баталсан төсвийн харьцуулалт	12



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

“Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаал, “Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд төсвөөс олгосон хөрөнгийг хууль тогтоомж, журам зааврын дагуу үр дүнтэй зарцуулж буй эсэхэд гүйцэтгэлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээллэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:

- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөж хуваарилсан эсэх
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитаар аймгийн БОАЖГ, түүний харьяа байгууллагууд, аймаг, сумдын ИТХ, Засаг дарга түүний харьяа байгууллага, аймгийн Татварын хэлтэс, холбогдох аж ахуйн нэгжүүдийг хамруулан тэдгээрийн ажлын тайлан, статистик мэдээ судалгааны материалд тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж, АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн аудитын журам, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан төрийн захиргааны байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, баримт бичгийг судлах зэргээр асуудлын шинжилгээний тохирох аргазүйг ашиглав.

Аудитын явцад цуглуулсан баримт материалыг шинжлэхдээ нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, нотлох баримтыг бүлэглэх, нэгтгэн дүгнэх зэргээр Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөөний аргазүйг ашиглан аудитын хөтөлбөр горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлсийг ажлын баримт материалд хавсаргав.



Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан байгаль хамгаалах, нөхөн сэргээхээр хэрэгжүүлсэн арга хэмжээг газар дээр нь шалгах болон холбогдох хүмүүстэй биечлэн уулзах горимыг хэрэгжүүлж чадаагүй болно.

АУДИТАД АШИГЛАСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Ойн тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Усны тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Амьтны тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Үндсэн мэдээлэл

Архангай аймгийн Засаг дарга Байгаль орчин, аялал жуулчлалын хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 16.2, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх хэсгийг үндэслэн тус яамтай хамтран ажиллах БОАЖЯ-ны сайд, Засаг даргын хооронд байгуулсан гэрээгээр орон нутгийн төсвөөс 2018 онд 478.5 сая төгрөгийн, 2019 онд 427.2 сая төгрөгийн хөрөнгөөр байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажилд зарцуулахаар гэрээ байгуулсан байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 2018 оны төсвийг Аймгийн ИТХ-ын 2017 оны 09 дүгээр тогтоолоор 478.6 сая төгрөг, 2019 оны төсвийг 2018 оны тогтоолоор 09 дүгээр тогтоолоор 427.2 сая төгрөгөөр тус тус нийт дүнгээр баталсан байна. Энэ батлагдсан төсвийг аймгийн ИТХТ-ийн 2018 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2018 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 35 арга хэмжээнд 478.5 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 469.1 сая төгрөгийг зарцуулжээ.

Мөн аймгийн Засаг даргын 2019 оны 3 дугаар сарын 01-ны өдрийн А/88 дугаар захирамжаар “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, үндэслэн 2019 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 25 арга хэмжээнд 427.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 407.2 сая төгрөгийг зарцуулжээ.



Санхүүгийн тайлангийн 2019 оны аудитаар байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас авто машины бэхэлгээ, аймгийн Номын санд тавилга, бэлэг дурсгалын зүйл, Тариат сумын Хадатын рашаанд тоглоомын талбай байгуулсан зэрэг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан нийт 5.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байхад арга хэмжээ авч ажиллах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлж аймгийн БОАЖГ-ын 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 186 дугаар албан бичгээр аудитаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна гэсэн хариуг ирүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх СХАА-наас аймгийн БОАЖГ-ын 2018-2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн №15 тоот удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн байна. Хяналт шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрсэнд холбогдох шийдвэрийг өгч ажиллажээ. Үүнд:

1. Булган уулын дурсгалт газрын явган аяллын замыг тохижуулах, Эрдэнэмандал сумын Ихнуурын экосистемийн хамгаалах, усны түвшинг нэмэгдүүлэх, биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг сайжруулах” ажлын гүйцэтгэл дутуу захиалагчид хүлээлгэн өгөөгүй зөрчил илэрсэнд албан шаардлага өгсөн.
2. Булаг шандны эхийг хашиж хамгаалсан ажлыг хүлээж авахдаа гэрээний 4.4 дэх заалтыг мөрдөж ажиллаагүй буюу тухайн сумын Засаг даргад хүлээлгэж өгөөгүй зөрчил илэрсэнд албан шаардлага өгөгдсөн байна.
3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хуурамч баримт бүрдүүлж давхардуулан 5.1 сая төгрөгийн гүйлгээг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоосон байна.

АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Д.Нэргүйбаатар, аудитор Г.Цог-Эрдэнэ нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

АУДИТЫН ХУГАЦАА:

Аудитыг 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлүүлж, талбарын ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 17-наас гүйцэтгэж аудитын тайлангийн төслийг 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор Тэргүүлэх аудиторт танилцуулж, аудитын тайланг тушаалаар баталгаажуулан 2020 оны 12 дугаар сарын 31-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан аудитын гүйцэтгэх хугацаа хойшлогдсон бөгөөд төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж чадаагүй болно.



БҮЛЭГ 1.

**БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЗАРЦУУЛАХ ТӨСВИЙГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ,
ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.**

А.1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НЬ НУТАГ ДЭВСГЭРТЭЭ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛААГҮЙ, ИТХ-ААС ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

А.1.1 Аймгийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу төлөвлөөгүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2018 оны зардлын төсвийг аймгийн ИТХ нийт дүнгээр, харин ИТХТ-ийн тогтоолоор хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг тус тус баталжээ. Тухайлбал: аймгийн ИТХ-ын 2017 оны 09 дүгээр тогтоолоор 478,576.9 сая төгрөг зарцуулахаар нийт дүнгээр баталсныг аймгийн ИТХТ-ийн 2018 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 35 арга хэмжээнд зарцуулах жагсаалтыг баталсан байна.

Харин аймгийн ИТХ-ын 2018 оны 11 сарын 30-ны 09 дүгээр тогтоолоор 2019 онд 13 арга хэмжээнд 427,200.0 төгрөг зарцуулах төсвийг баталсан байна. Уг жагсаалтыг аймгийн Засаг даргын 2019 оны 3 дугаар сарын 01-ны өдрийн А/88 дугаар захирамжаар 25 арга хэмжээнд зарцуулахаар болгож задалсан байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 2018, 2019 оны төсвөөр хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтаас харвал аймгийн Засаг дарга, БОАЖГ-ын даргад хууль тогтоомжоор олгосон эрх үүрэгт тусгаагүй, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд хамаарахгүй арга хэмжээнд нийт 208 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж батлуулсан байна.

Тухайлбал: МУЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах" журмын 3 дахь заалтад тусгагдсан арга хэмжээнд нийцэж байгаа эсэхийг тулган шалгахад 2018 онд аялал жуулчлалын чиглэлийн 5 арга хэмжээнд 28.0 сая төгрөг, хог хаягдлын 7 арга хэмжээнд 14.1 сая төгрөг, бусад 19 арга хэмжээнд 60.9 сая төгрөгийг нийт 31 арга хэмжээнд 103.0 сая төгрөг, 2019 онд ашигт малтмал, түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласан газрын эвдрэлийг нөхөн сэргээхтэй холбоотой 31.0 сая төгрөг, аялал жуулчлалтай холбоотой 34.0 сая төгрөг, Төрийн тахилга наадам зохион байгуулах 30.0 сая төгрөг, байгаль орчны зөвлөл, салбарын албан хаагчдыг туршлага судлуулах чадавхижуулахад 10.0 сая төгрөг нийт 105.0 сая төгрөг зориулалт бусаар зарцуулахаар төлөвлөсөн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзэх)

Энэ нь төсвийг батлуулахын өмнө хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг гаргаж аймгийн ИТХ-д танилцуулаагүйтэй холбоотой гэж үзэж байна.

Өөрөөр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө арга хэмжээний хэрэгцээ шаардлага болон журмын дагуу зарцуулахаар төсвийн төлөвлөлтийг хийгээгүй байна.



/Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын 2020.12.07-ны өдрийн 04/1361 дугаар албан бичиг/

Харин байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гарч буй зөрчлийг бууруулах зорилготой эргүүл шалгалт хийх төлөвлөгөөг аймгийн МХГ болон хүчний байгууллагатай хамтран боловсруулж ИТХ-аар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Мөн 2019 онд Хууль бусаар ашигт малтмал ашиглахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор аймгийн Засаг даргын 2019 оны А/188 дугаар захирамжаар холбогдох хууль хяналтын байгууллагуудыг хамруулсан ажлын хэсгийг байгуулан алт олборлолт явагдаж байгаа Цэнхэр сумын Орхон багт хяналтын постыг 2019 оны 05 дугаар сараас эхлүүлэн 10 хоногийн ээлжээр тогтмол ажиллуулаад байна. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөөг жилээр нь гарган батлуулан 158 удаагийн хяналт шалгалтыг хийгээд байна. Тайлант хугацаанд Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтанд 400 шахам иргэн, аж ахуйн нэгж байгууллага, өрх айл хамрагдаж 11 зөрчил илрүүлэн 1200000 төгрөгийн торгууль, 3.970.351 төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж 70% барагдуулаад байна. Зөрчлийн тухай, Ойн тухай хуулиуд, Ойгоос мод бэлтгэх журам, Түлшний модны стандартаас хэсэгчлэн бэлтгэсэн 700 гаруй гарын авлагыг тарааж заавар, зөвлөмж өгч ажилласан байна.

/Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын 2020.12.03-ны өдрийн 08/1342 дугаар бичиг/

А.1.2. Аймгийн ИТХ нь хуулиар олгогдсон эрхийн хүрээнд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэнд нь хяналт тавьж ажиллаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсвийг 2018 онд 30 арга хэмжээнд 478,576.9 сая төгрөгийг аймгийн ИТХТэргүүлэгчдээр, 2019 онд 25 арга хэмжээнд 427,200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар аймгийн ЗД-ын захирамжаар баталсан.

Харин байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэнд нь хяналт тавьсан талаарх ажлын тайлан, нотлох баримт байхгүй байна. /Аймгийн ИТХ-ын 2020.12.09-ны өдрийн 159 дугаар албан бичгийг үндэслэв/.

Мөн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.1-д заасан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь, хэмжээг мөрдөөгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 /сая.төг/

№	Орлогын нэр төрөл	2018			2019		
		Гүйцэтгэлээр орлого	Зарцуулбал зохих хөрөнгө	Батлагдсан хөрөнгө	Гүйцэтгэлээр орлого	Зарцуулбал зохих хөрөнгө	Батлагдсан хөрөнгө
1	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2,413.8	362.1	-	166.1	24.9	8.5
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	17.1	8.6	43.0	17.2	8.6	15.0
3	Ойн нөөц ашигласны төлбөр	358.5	304.7	240.3	320.0	272.0	197.4
4	Ус,рашаан ашигласны төлбөр	426.9	149.4	132.0	295.0	103.3	79.0
5	Бусад арга хэмжээнд зарцуулах хөрөнгө	-	-	63.3	-	-	127.3
НИЙТ ДҮН		3,216.3	824.8	478.6	798.3	408.8	427.2


Дээрх (А.1.1-А.1.2-д тусгасан) илрүүлэлтийн дүнд үндэслэн аймгийн Засаг даргад байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөх, төсвийн төслийг тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтын хамт ИТХ-аар хэлэлцүүлж батлуулж байх, аймгийн ИТХ-ын даргад байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт шалгалт хийх үүргээ хэрэгжүүлж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

А.2. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГООС БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ТУХАЙН ТӨСВИЙН ЖИЛД ЗАРЦУУЛАХ ТӨСВИЙГ БАТЛАХДАА ХУУЛЬД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭГ МӨРДӨӨГҮЙ БАЙНА.

А.2.1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөлт хийгээгүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 15 хувиар тооцож зардлын төлөвлөлт хийх ёстой байхад 2018 онд төлөвлөлт огт хийгдээгүй, 2019 онд 8.5 сая төгрөг төлөвлөсөн байна.

Төлөвлөлтийг графикаар харуулбал:



Төлөвлөлтийн талаар тодруулахад байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны “Ойгоос хуш модны самар түүж бэлтгэх, хориглох тухай” А/388 дугаар тушаалыг үндэслэн үйлдвэрлэл болон ахуйн зориулалтаар хуш модны самрыг түүж бэлтгэсэн орлого суманд төвлөрч тухайн сумын Засаг дарга зарцуулалтын төлөвлөлт хийсэнтэй холбоотой гэсэн тайлбарыг ирүүлсэн. /Эх сурвалж: Аймгийн


БОАЖГ-ын 2020 оны 12 сарын 21-ний 347 тоот албан бичиг/

Гэтэл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 7-р зүйлд зааснаар "хуш модны самар" түүж бэлтгэх нь ойн дагалт баялаг буюу ойн нөөц ашигласны орлогод тооцогдох ёстой. Уг орлогыг ургамал ашигласны орлогоор тооцон төлөвлөвөл түүнээс байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалахад эргэн зарцуулах зардлыг хуульд зааснаас бага хувиар (Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.4-д “Ойн нөөц ашигласны орлогоос 85%-г зарцуулах ёстой”) тооцож төлөвлөн, зарцуулахаар байна.

А.2.2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос зарцуулах хэмжээг хуульд заасан хувь хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.2-д заасан ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 50 хувиар тооцож зардлын төлөвлөлт хийх ёстой байтал төлөвлөлтийг 2-5 дахин нэмэгдүүлэн баталсан байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг графикаар харуулбал:



Графикаас харахад төвлөрүүлсэн орлогоос зарцуулбал зохих хуулийн хэмжээнээс 2018 онд 5 дахин их буюу 43.0 сая төгрөгөөр, 2019 онд 2 дахин их буюу 15.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.2 дахь заалтыг зөрчсөн байна. Энэ нь бусад арга хэмжээнд хуульд заасан хэмжээгээр зарцуулах төсвийг бууруулахад нөлөөлж байна.

А.2.3. Газрын нөөц ашигласны төлбөрийн орлого орон нутагт төвлөрүүлдэггүй тул зардлын төлөвлөлт хийгдээгүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө газрын нөөц ашигласны төлбөрийн орлогоос Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.3-д заасан хувь хэмжээгээр төлөвлөлт хийгээгүй байна. Учир нь газрын нөөц ашигласны төлбөрийн орлого орон нутагт төвлөрүүлдэггүй байна.

А.2.4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээг 25.4-35.6 хувиар бууруулан байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.4-д заасан ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 85 хувиар тооцож зардлын төлөвлөлт хийх ёстой байтал төлөвлөлтийг 25.4-35.6 хувиар бууруулан баталсан байна.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг графикаар харуулбал:




Графикаас харахад төвлөрүүлсэн орлогоос зарцуулбал зохих хэмжээнээс 2018 онд 35.6 хувь буюу 78.9 сая төгрөгөөр, 2019 онд 25.4 хувь буюу 72.6 сая төгрөгөөр тус тус бууруулан баталсан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 7-р зүйлд "...ойгоос бэлтгэж ашигласан хэрэглээний бүх төрлийн хэрэглээний мод, түлээнд төлбөр ногдуулахаас гадна "Ойн дагалт баялгийн нөөц самар мөөг, давирхай, шилмүүс, мөчир, үр, хусны шүүсэнд төлбөр ногдуулна" гэж заасан байна. Мөн хуулийн 18.1.4-д "ойн нөөц ашигласны орлогын 85% хувийг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна" гэж тодорхой заасан байхад хушны самар түүх бэлтгэх төлбөрийн орлогыг ургамал ашигласны нөөцийн төлбөрийн орлогоор тооцон төлөвлөж байгаа нь байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд уг орлогоос эргэн зарцуулагдах хөрөнгийг хуульд зааснаас бага хэмжээгээр төлөвлөж зарцуулах нөхцлийг бий болгох хууль зөрчсөн үйлдэл болж байна.

A.2.5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээг 11.7-23.5 хувиар бууруулан төлөвлөсөн байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.5-д заасан ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос 35 хувиар тооцож зардлын төлөвлөлт хийх ёстой байтал төлөвлөлтийг 11.7-23.5 хувиар бууруулан баталсан байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг графикаар харуулбал:



Графикаас харахад төвлөрүүлсэн орлогоос зарцуулбал зохих хэмжээнээс 2018 онд 11.7 хувь буюу 17.4 сая төгрөгөөр, 2019 онд 23.5 хувь буюу 24.3 сая төгрөгөөр тус тус бууруулан баталсан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Зардлын төлөвлөлтөөс харахад байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулбал зохих зардлын төсвийг 2018 онд нийт 414.0 сая төгрөг, 2019 онд нийт 130.4 сая төгрөгөөр тус тус хуульд заасан хэмжээнээс багаар тооцож төлөвлөсөн байна. Энэ хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн төлөвлөсөн арга хэмжээнүүд хэрэгжихгүй орхигдож, байгалийн нөөц нөхөн сэргээгдэх боломж алдагдахад хүрч байна.

Аудитаас дээрх (A.2.1-A.2.5 тусгасан) илрүүлэлтийн дүнд үндэслэн МУЗГ-ын 2014 оны 43-р тогтоолоор баталсан журамд зааснаас өөр зориулалт арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөхгүй байх, төсвийг нийт дүнгээр батлуулахгүй байх, төсвийн төслийг тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтын хамт аймгийн Засаг даргад танилцуулж, ИТХ-аар хэлэлцүүлж батлуулах албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т хүргүүлээ.



БҮЛЭГ 2

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХУВААРИЛСАН ХӨРӨНГИЙН 25.8 ХУВИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН АРГА ХЭМЖЭЭНД ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.

Б.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС 208.0 САЯ ТӨГРӨГИЙГ ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.

Б.1.1. Зарим гүйцэтгэгч арга хэмжээг гэрээний дагуу хугацаанд гүйцэтгээгүй байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 2018 онд 62 арга хэмжээг 419.9 сая төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлэх гэрээ байгуулснаас “Эрдэнэмандал сумын Их нууранд хөв цөөрөм байгуулах” 30.0 сая төгрөг, “Булган хайрханы тохижилт хамгаалалт” хийх 24.2 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгч нар гэрээний хугацаанд хүлээлгэн өгөөгүй байна. Харин 2019 онд нийт 407.2 сая төгрөгийн 25 арга хэмжээ хэрэгжүүлснээс 13 арга хэмжээг 261.6 сая төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгч нартай гэрээ байгуулсан байна. Эдгээрээс нийт 152.7 сая төгрөгийн дүн бүхий ажлын 8 гүйцэтгэгч гэрээт ажлыг төлөвлөсөн хугацаанаас 5-55 хоног хэтрүүлэн хүлээлгэн өгсөн. Үүнийг хүснэгтээр харвал:

Арга хэмжээний нэр	Гэрээгээр хүлээлгэн өгөх хугацаа	Хүлээн авсан актын			Хүснэгт 2
		дугаар	огноо	хоног	Хугацаа хэтэрсэн Алданги /мян.төг/
Цэцэрлэг хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх байнгын усалгаатай болгох ажил	2019.11.01	№06	2019.11.05	5	118.2
Цэнхэр сумын Орхон багт уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт байгаль орчны хохирлын үнэлгээ нөхөн төлбөрийг тооцох ажлын зөвлөх үйлчилгээ	2019.11.30	№0	2019.12.17	17	195.5
Хадат, Мухар хужирт рашааны эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх, орчны бохирдлоос сэргийлэх, ариун цэврийн байгууламжийн сайжруулах	2019.08.05	№05	2019.10.01	55	1100.0
Ойд арчилгаа хийх насны 1,2-р ангид гэрэлжүүлэх, тохируулах	2019.11.03	№08	2019.11.08	5	24.0
Нэн ховор, ховор амьтны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авах	2019.12.01	№09	2019.12.06	5	20.0
Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2019.10.23	№07	2019.11.07	14	42.0
Хүний нөлөөнд их хэмжээгээр өртөж байгаа нэг зүйл ургамлыг хамгаалах, тарималжуулах, үр түүх	2019.09.01	№06	2019.10.17	37	111.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх	2019.06.21	№0	2019.07.07	7	24.5
	2019.10.31	№02	2019.11.15	15	13.5
Дүн				160	1648.7



Мөн “Хашаат суманд хөв цөөрөм байгуулах” ажлын гүйцэтгэгч нь ажлыг гэрээт хугацаанд бүрэн хийж дуусгаагүй байхад санхүүжилт 14.9 сая төгрөгийг бүрэн олгосон байна.

Цаг үеийн нөхцөлтэй холбоотойгоор 2018, 2019 онд гүйцэтгэсэн ажлын чанар, ашиглалтын байдлыг газар дээр нь очиж шалгаагүй болно. Иймээс хэрэгжилт, үр дүнд дүгнэлт өгч чадаагүй.

Б.1.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөөгүй, Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолоор батлагдсан журмын 3-т заасан арга хэмжээнд зарцуулаагүй байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төсвийг МУЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах" журмын 3 дахь заалтад тусгагдсан арга хэмжээ зарцуулахаар төлөвлөөгүйн (Бүлэг 1-ийн А.1.1-д тусгасан) улмаас төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал: 2018 онд аялал жуулчлалын чиглэлийн 5 арга хэмжээнд 28.0 сая төгрөг, хог хаягдлын 7 арга хэмжээнд 14.1 сая төгрөг, бусад 19 арга хэмжээнд 60.9 сая төгрөгийг нийт 31 арга хэмжээнд 103.0 сая төгрөг, 2019 онд ашигт матлтмал, түгээмэл тархац байгалийн баялаг ашигласан газрын эвдрэлийг нөхөн сэргээхтэй холбоотой 31.0 сая төгрөг, аялал жуулчлалтай холбоотой 34.0 сая төгрөг, Төрийн тахилга наадам зохион байгуулах 30.0 сая төгрөг, байгаль орчны зөвлөл, салбарын албан хаагчдыг туршлага судлуулах чадавхижуулахад 10.0 сая төгрөг нийт 105.0 сая төгрөг, дээрх онуудад бүгд 208.0 сая төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 25.6 хувийг зориулалт бусаар зарцуулжээ.

Аудитаар илэрсэн дээрх зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байхын тулд МУЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлд заасан арга хэмжээнд зарцуулахаар төсвийг төлөвлөж байх, ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээний хэрэгжилтэнд тухай бүр хяналт тавьж, гэрээний үүргийг биелүүлэхийг шаардах, гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т хүргүүлжээ.

Б.2. ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГААГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

Б.2.1. Арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар худалдан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2018 онд нийт 30 арга хэмжээнд 478.5 сая төгрөгийг зарцуулахаас 12 арга хэмжээний 343.6 сая төгрөгийг харьцуулалтын аргаар, тендер шалгаруулалт зохион байгуулах төсөвт өртэй байна. Үүнээс 7 арга хэмжээний 260.6 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг



харьцуулалтын аргаар аймгийн ОНӨГ-т цахимаар зохион байгуулсан ба 5 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Харин 2019 онд 427.2 сая төгрөгийн 25 арга хэмжээний 14 нь хуулийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулахаар төсөвт өртөгтэй байгаагаас 198.8 сая төгрөгийн 6 арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГ-т зохион байгуулсан, 8 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

2018 оны тухайд “Булган уулын тохижилт”, “Эрдэнэмандал суманд хөв цөөрөм байгуулах” ажлууд тайлант ондоо багтан хэрэгжээгүй нь гүйцэтгэгчтэй холбоотой байгаа бол 2019 оны “Хашаат суманд хөв цөөрөм байгуулах” ажил тайлант онд бүрэн хэрэгжээгүй нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил оройтож 2019 оны 11 дүгээр сард гэрээ байгуулсантай холбоотой байна.

Б.2.2. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна.

ОНӨГ-аас байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар 2018 онд 7 арга хэмжээ, 2019 онд 6 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан байна

Б.2.3. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна.

БОАЖГ-аас 2018 онд 83.0 сая төгрөгийн 5 арга хэмжээ, 2019 онд 49.8 сая төгрөгийн 3 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, тухайн арга хэмжээний төсвийг хувааж шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.4-д заасан “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, мөн хуулийн 33.1-д “Бараа ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын арга хэрэглэж болно” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Өөрөөр хэлбэл гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна.

Аудитын дүнд үндэслэн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний ИТХ-аар батлагдсан жагсаалт, төсөвт өртөгт үндэслэн хууль журамд заасны дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах, тухайн арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй ил тод өрсөлдөх боломжийг хангах арга хэмжээ авах албан шаардлагыг БОАЖГ-т, худалдан авах ажиллагааг тухайн онд бүрэн хэрэгжих боломжийг хангахаар төлөвлөж, зохион байгуулах арга хэмжээ авах зөвлөмжийг ОНӨГ-т тус тус хүргүүллээ.



БҮЛЭГ 3

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн боловч үр нөлөө хангалтгүй байна.

В.1. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

В.1.1. Арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, баталгаажуулаагүй байна.

Гэрээний хэрэгжилтэнд захиалагчаас тавих хяналт хангалтгүйгээс 2018 онд “Эрдэнэмандал сумын Их нуурын хөв цөөрөм байгуулах” 30.0 сая төгрөгийн ажил, “Булган уулын тохижилт хийх” 24.2 сая төгрөгийн ажлуудыг гэрээний хугацаанд ашиглалтанд оруулаагүй байна. Мөн “булгийн эх хашиж хамгаалах” ажлыг хүлээж авсан актгүй, сумын Засаг дарга хүлээж авсан тодорхойлолтгүй зэрэг 3 арга хэмжээнд 5.6 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн.

Харин 2019 онд нийт 407.2 сая төгрөгийн ТАХ-нээс 13 арга хэмжээг 261.6 сая төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгч нартай гэрээ байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилтэнд хяналт тавиагүйгээс 8 гүйцэтгэгч гэрээт ажлыг хугацаанаас 5-55 хоног хэтрүүлэн хүлээлгэн өгсөн байна. Тэдгээр гүйцэтгэгч нарт хугацаа хэтрүүлсэн хоногт ногдох алданги нийт 1.6 сая төгрөгийг санхүүжилтээс суутгалгүй олгосон нь ажил гүйцэтгүүлэх гэрээний ерөнхий нөхцлийн 13.1¹-д заасныг зөрчсөн байна.

В.1.2. Арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгоогүй байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 2018, 2019 оны хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримтаар тулгаж гэрээний хэрэгжилт, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон эсэхийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. 2018 онд БОАЖГ-ын 7 албан хаагчид Өмнөговь аймагт туршлага судлах уулзалтад оролцсон гэх 940.0 мянган төгрөгийн томилолтыг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй байхад тооцож олгосон. БОАЖГ-ын дарга гадаадад туршлага солилцох ажлын тийзний үнэ 1,990.3 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч туршлага солилцох удирдамж, ажлын тайланг анхан шатны баримтанд хавсаргаагүй зөрчил илэрснийг аудитын явцад зөрчлийг арилгуулсан.

2. Булгийн эхийг хашиж хамгаалсан ажлыг холбогдох сумын Засаг дарга нарт хүлээлгэн өгөөгүй буюу гэрээний 4.4-д заасныг хэрэгжүүлээгүй байхад 2018 онд 5.6 сая төгрөг, 2019 онд 15.0 сая төгрөгийг олгосон, ойн сан эзэмших гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан 4 нөхөрлөлд 7.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн, Хашаат суманд хөв цөөрөм байгуулах ажлын гүйцэтгэгч Тайгер дизайн ХХК нь ажлыг гэрээнд заасан хугацаанд бүрэн хийж дуусгаагүй байхад

¹ Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно.



санхүүжилт болох 14900.0 мянган төгрөгийг бүрэн олгосон зэрэг зөрчил илэрсэн.

В.1.3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтад тавих ТЕЗ-ийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч үр нөлөө хангалтгүй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх СХАА-наас байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 2018- 2019 оны 06 сар хүртэлх хугацааны зарцуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2019 онд хийсэн байна. Уг хяналт шалгалтаар зориулалт бус, давхардуулж олгосонтой холбоотой нийт 5,082.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдсан байх бөгөөд 1,000.0 мянган төгрөг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн мэдээлэлтэй байна. Мөн тус хяналт шалгалтаар 4 заалт бүхий албан шаардлагыг шалгагдагч байгууллагад хүргүүлж биелэлтийг тооцож ажилласан байна.

Гэвч энэ аудитаар зөрчил давтагдан илэрч байгаа өмнө хяналт шалгалтаас өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой гэж үзэж байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д "... хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын алба байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж заасан байх бөгөөд санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж байгаа боловч хуулийн хэрэгжилтэнд тавих хяналт орхигдсоноос дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна гэж үзэж байна.

Аудитын дүнд үндэслэн зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байхын тулд ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээний хэрэгжилтэнд тухай бүр хяналт тавьж, гэрээний үүргийг биелүүлэхийг шаардах, гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг БОАЖГ-т хүргүүлээ.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хуульд заасны дагуу төлөвлөж, хуваарилаагүй байна.
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжид заасан арга хэмжээнд үр дүнтэй зарцуулаагүй байна.
3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн боловч үр нөлөө хангалтгүй байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 677.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоох, арилгах үүднээс аймгийн БОАЖГ-т албан шаардлага хүргүүлээ.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Б. Батжаргал танаа

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” гэсэн бүрэн эрхийн дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төсвийг батлахдаа зардлын хэмжээг хуульд заасан хувь хэмжээгээр тооцсон эсэх, хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт нь хууль журамд нийцсэн эсэхийг ИТХ-аар хэлэлцүүлэх, баталсан төсвийн хэрэгжилт, үр дүнд шалгалт хийж холбогдох арга хэмжээг авч байх

Ингэснээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тавих хяналт сайжирч аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх болно.

Аймгийн Засаг дарга Д. Золжаргал танаа

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож төлөвлөх
2. МУЗГ-ын 2014 оны 43 тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлд заасан арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөх, сум, орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэх
3. Төсвийн төслийг тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтын хамт ИТХ-аар хэлэлцүүлж батлуулж байх
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллагаар хангуулж ажиллах

Ингэснээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тухайн жилийн зорилтод түвшин хангагдаж, үр дүн, үр ашиг нэмэгдэх болно.



Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын
дарга Н.Баянмөнх танаа

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын хүрэх үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэх

1. Зардлын хэмжээг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож төлөвлөх
2. МУЗГ-ын 2014 оны 43 тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлд заасан арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж, жагсаалтыг аймгийн Засаг даргаар хянуулж байх
3. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсвөөс санхүүгийн дэмжлэг олгох тухай хуульд журамд нийцсэн шалгуур болохуйц журмын боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулах
Тухайлбал: Байгалийн нөөцийн менежментийн хамтын нөхөрлөлийг дэмжих, байгаль хамгаалагчид урамшуулал олгох, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсвөөр бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээ, булаг шандын эхийг хашиж хамгаалах гэх мэт арга хэмжээний тавигдах шаардлага, шалгуурыг тодорхой болгож, олон нийтэд ил тод мэдээллэх
4. Батлагдсан төсөвт өртөгт үндэслэн худалдан авах ажиллагааны журмыг сонгож хэрэгжүүлэх, ОНӨГ-т худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсөвт батлагдснаас хойш хуульд заасан хугацаанд хүргүүлж байх
5. Цэцэрлэг хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр 2017-2020 онд тарьсан мод, бут, сөөгийг он тус бүрээр тэмдэгжүүлэн тооллого хийж баримтжуулан ХТҮГ-т хүлээлгэн өгөх

Ингэснээр аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гарахгүй байх нөхцөл бүрдэх бөгөөд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зориулан төсвөөс олгосон хөрөнгийг арвилан хэмнэллтэй, үр дүнтэй зарцуулах болно.


Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 05 сарын 01-ны дотор холбогдох нотлох баримтын хамт Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аймгийн БОАЖГ-аас аудитын тайлантай холбоотой саналгүй гэсэн болно.

Уг хэмжээнд
Төсвийн
7/4



**АРХАНГАЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**
65133 Архангай аймаг, Эрдэнэбулган сум
Утас/Факс: (976) 7033-3223
Э-мэйл: arkhangai_env@mail.com

2020.12.31 № 358
танай 2020.12.30-ны № 556-т

**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аймгийн хэмжээнд 2018-2019 онд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аудитын тайланд тусгах саналгүй болохыг үүгээр уламжилъя.


ДАРГА *[Signature]* Н.БАЯНМӨНХ



Тайлан баталгаажуулсан тушаал